



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2021.03.25 № 171

танай _____-ны № _____-т

**ӨГИЙНУУР СУМЫН ЗАСАГ
ДАРГА Ш.ҮҮРЦАЙХ ТАНАА**

Архангай аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу танай байгууллагын 2020 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Аудитын тайлан, дүгнэлт, менежмент захидлыг, албан шаардлагын хамт хүргүүллээ. Шийдвэрийн биелэлтийг хугацаанд нь хэрэгжүүлж, хариу ирүүлнэ үү.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.УЛАМБАЯР

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Өгийнуур сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: АРА-2021/11/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Цэцэрлэг хот

2021 он

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд тэргүүлэх аудитор: Д. Уламбаяр

Утас: 70333141 UlambayarD@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Байгалмаа

Утас: 70332860 BaigalmaaT@audit.gov.mn

Аудитор: Х.Алтанчимэг

Утас:90060105 Altanchimegkh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын гэрчилгээ.....	
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3.Аудитын тайлан	11
3.1. Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	12
3.5.1 Мөнгөн хөрөнгө	12
3.5.3 Авлага	12
3.5.6 Бараа материал	12
3.5.7 Үндсэн хөрөнгө.....	13
3.5.8 Өр төлбөр	14
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо	15
3.5.10 Орлогын данс.....	15
3.5.11 Зардлын данс.....	15
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	15
3.7 Шилэн дансны мэдээлэл.....	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	18
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	19
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	21
4. Менежментийн захидал	22
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
ХАОАТ	Хүн амын орлогын албан татвар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан

1. Аудитын гэрчилгээ

 АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 65130 Цэцэрлэг, Архангай аймаг Утас/Факс: 976-70333141 И-мэйл: arkhangai@audit.gov.mn	<p>ӨГИЙНУУР СУМЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ Ш.ҮҮРЦАЙХ ТАНАА</p>
<u>2021.03.25</u> № <u>128</u>	
танай _____ -ны № _____ -Т	
АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ	
Зөрчилгүй дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Өгийнуур сумын ТЭЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Өгийнуур сумын ТЭЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.</p>	
Дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
Бусад мэдээлэл	
<p>Сумын засаг дарга бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Сумын засаг даргын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 21 зорилын хүрээнд 100 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 86.1 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.</p> <p>Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.</p>	
Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага	
<p>Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын 2015 оны 341-р тушаалаар баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.</p> <p>Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.</p>	

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



ДУЛАМБАЯР

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	576,520.4	613,069.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	62,179.2	57,417.2
33	АВЛАГА	288,388.0	282,777.8
35	БАРАА МАТЕРИАЛ	225,953.2	272,874.7
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,956,268.2	3,493,165.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,956,268.2	3,493,165.6
39200	Биет хөрөнгө	2,831,294.8	3,369,412.2
39300	Биет бус хөрөнгө	124,973.4	123,753.4
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,532,788.6	4,106,235.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.0	7,132.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	7,132.0
41300	Өглөг	0.0	7,132.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,532,788.6	4,099,103.3
51	Засгийн газрын хувь оролцоо	3,532,788.6	4,099,103.3
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,381,535.8	3,381,535.8
51200	Хуримтлагдсан үр дүн	-511,604.8	120,614.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	662,857.6	596,953.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,532,788.6	4,106,235.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,612,271.2	3,129,771.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	98,251.1	113,989.6
110	Орлогын албан татвар	74,752.8	92,835.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	74,752.8	92,835.4
113	Хөрөнгийн албан татвар	2,910.0	3,120.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	20,588.2	18,034.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	169,100.0	838,426.4
120	Нийтлэг татварын бус орлого	169,100.0	838,426.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,344,920.1	2,177,355.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,534,091.2	2,486,674.6

Өгийнуур сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн төвсийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,534,091.2	2,486,674.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,085,121.0	2,405,477.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,325,579.5	1,551,639.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	166,431.9	197,733.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	117,195.7	121,075.8
2104	Хангамж, бараа материалын зардал	94,399.5	94,505.2
2105	Нормативт зардал	110,073.7	91,381.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,198.6	9,988.3
2107	Томилот, зочны зардал	9,148.1	4,190.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,289.8	57,364.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	223,804.1	277,597.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	448,970.3	81,197.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	78,180.0	643,096.6
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	85,904.8	76,781.9
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-7,724.8	566,314.7

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,540,513.4	3,540,513.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	12,800.0	12,800.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,553,313.4	3,553,313.4
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-12,800.0	-12,800.0
9	Тайлант үеийн үр дүн	-7,724.8	-7,724.8
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,532,788.6	3,532,788.6
11	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,532,788.6	3,532,788.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	65,904.4	65,904.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,598,693.0	3,598,693.0
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-65,904.4	-65,904.4
19	Тайлант үеийн үр дүн	566,314.7	566,314.7
20	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,099,103.3	4,099,103.3

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
------	---------------------	----------------	-----------------

Өгийнуур сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн төвсийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,523,143.2	2,364,901.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	98,251.1	113,989.6
110	Орлогын албан татвар	74,752.8	92,835.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	74,752.8	92,835.4
113	Хөрөнгийн албан татвар	2,910.0	3,120.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	20,588.2	18,034.2
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	15,449.2	13,411.9
1181	Газрын төлбөр	1,030.0	1,440.3
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	4,109.0	3,182.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	78,957.0	73,556.3
120	Нийтлэг татварын бус орлого	78,957.0	73,556.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,345,935.1	2,177,355.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,357,850.4	2,221,473.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,357,850.4	2,221,473.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,907,176.6	2,140,275.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,327,477.3	1,551,639.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	166,339.1	197,733.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	118,857.2	116,511.7
2104	Хангамж, бараа материалын зардал	88,864.7	66,483.3
2105	Нормативт зардал	113,539.5	76,304.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,001.2	16,914.9
2107	Томилолт, зочны зардал	9,407.3	4,244.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,632.0	58,376.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,058.3	52,066.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	450,673.8	81,197.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	165,292.8	143,428.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	111,164.6	93,190.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	111,164.6	93,190.0
2200	Дотоод эх үүсвэрээр	111,164.6	93,190.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-111,164.6	-93,190.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-71,000.0	-55,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	71,000.0	55,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-16,871.8	-4,762.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	79,051.0	62,179.2

10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	62,179.2	57,417.2
----	---	----------	----------

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,423,614.50	2,294,183.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,223,641.40	2,167,133.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,175,787.70	2,127,387.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,552,762.50	1,547,026.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	208,066.80	197,157.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	116,531.50	116,511.70
2104	Хангамж, бараа материалын зардал	67,241.40	63,579.30
2105	Нормативт зардал	98,990.70	76,169.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,869.00	20,112.90
2107	Томилт, зочны зардал	4,658.40	4,244.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	54,178.60	52,654.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,488.80	49,931.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,853.70	39,745.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,853.70	39,745.90
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	79,973.10	72,049.80
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	120,000.00	55,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,423,614.50	2,302,011.10
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,555,885.80	1,514,648.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	648,693.00	686,522.50
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	33,206.00	32,940.90
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	185,829.70	67,899.70
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		10,302.40
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		18,130.30
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,068.00	1,064.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	6	6
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	137	136
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	787	787
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	533	533
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	254	254
632	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	-	-
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	137	137

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	32,619.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	32,619.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,104.9

Өгийнуур сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн төвсийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	4,612.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	576.6
2104	Хангамж, бараа материалын зардал	3,415.1
2105	Нормативт зардал	1,500.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,415.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,585.0
II	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	515.0
1311	Дотоод эх үүсвэрээр	515.0
131101	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	32,619.9
131103	Нэмэлт санхүүжилтийн орлого	32,619.9

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Өгийнуур сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч Ш.Үүрцайх танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 16-аас 2021 оны 03 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Алтанчимэг гүйцэтгэв.

Өгийнуур сумын ТЭЗ нь 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 04-ны өдөр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Өгийнуур сумын ТЭЗ нь “Дэлхийд нэртэй үзэсгэлэнт Өгий нуурынхаа байгалийн тэнцвэрт байдлыг хадгалан, аялал жуулчлал, бизнес үйлдвэрлэл хөгжсөн, эрчимжсэн хөдөө аж ахуйтай биеэ даасан эдийн засагтай, ард иргэдийнхээ амьдрах таатай орчныг бүрдүүлж, нийгмийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэсэн бүсийн загвар сум болох эрхэм зорилго”-ын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Өгийнуур сумын төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл санхүүгийн нэгтгэсэн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, Сангийн сайдын 2015 оны 341-р тушаалаар баталсан журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд төсвийн 8 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэж нэгтгэлийг онлайнаар бэлтгэж байна.

Тайлант жил Өгийнуур сумын ТЭЗ-ийн санхүүгийн тайланд нэгтгэгддэг төсөвт байгууллагуудад аймгийн санхүүгийн хяналт аудитын албанаас 2019-2020 оны 1-р улирлын байдлаар хяналт шалгалт хийгдсэн байна.

Өгийнуур сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд ДУНД гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдлийн түвшинг Дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинд шинж чанар ба агуулгын хувьд өөрчлөлт ороогүй тул төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшин болох үр дүнгийн тайлангийн нийт зардал **2,563,456.4** мянган төгрөгийн 1 хувь **25,634.5** мянган төгрөгөөр тооцлоо.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл **62,179.2** мянган төгрөг, эцсийн үлдэгдэл **57,417.2** мянган төгрөг болж, **4,762.0** мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт(-)
Төрийн сангийн харилцах	62,179.20	57,417.20	(4,762.00)
НИЙТ МӨНГӨН ХӨРӨНГИЙН ДҮН	62,179.20	57,417.20	(4,762.00)
Үүнээс, байгууллагын төрлөөр:			
Сум хөгжүүлэх сан	799.6	10,207.0	9,407.40
Орон нутгийн ерөнхий орлого	51,876.8	39,287.0	(12,589.80)
Орон нутгийн хөгжлийн сан	9,502.9	7,923.2	(1,579.70)
НИЙТ МӨНГӨН ХӨРӨНГИЙН ДҮН	62,179.2	57,417.2	(4,762.00)

Эх сурвалж: Өгийнуур сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт мөнгөн хөрөнгийн 17.8 хувь буюу 10,207.0 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн, 68.4 хувь буюу 39,287.0 мянган төгрөгийг орон нутгийн ерөнхий орлого, 13.8 хувь буюу 7923.2 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн үлдэгдэл тус тус эзлэж байна.

3.5.2 Авлага

Авлагын эхний үлдэгдэл **288,388.0** мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 282,777.8 мянган төгрөг болж, 5,610.2 мянган төгрөгөөр буурсан байна. Нийт авлагыг сум хөгжүүлэх сангийн авлага эзлэж байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

Авлагын ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт(-)
Сум хөгжүүлэх сан	288,388.0	282,777.8	5,610.2
Нийт дүн	288,388.0	282,777.8	5,610.2

Эх сурвалж: Өгийнуур сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл **225,953.1** мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 272,874.7 мянган төгрөг болж 46,921.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал		6443.1	6,443.1
Эм боох материал	8,487.5	25,996.9	17,509.4
Бичиг хэргийн материал	5,868.1	5,728.3	-139.8

Аж ахуйн материал	204,452.3	232,774.8	28,322.5
Түлш шатах тослох материал	4,648.9		-4,648.9
Хүнсний материал	1,296.2	331.6	-964.6
Мал амьтад	1200	1600	400
Дүн	225,953.1	272,874.7	46,921.6
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Ахлах сургууль	116,184.5	149,249.3	33,064.8
ЗДТГ	33,230.4	36,289.4	3,059.0
ИТХ	44.0	44.0	0.0
Соёлын төв	6,478.6	6,153.6	-325.0
Цэцэрлэг	22,659.4	28,513.7	5,854.3
ЭМТ	47,356.2	52,624.7	5,268.5
Дүн	225,953.1	272,874.7	46,921.6

Эх сурвалж: Өгийнуур сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт бараа материалын 54.7 хувь буюу 149,249.3 мянган төгрөгийн бараа материал нь ахлах сургуулийн, 13.3 хувь буюу 36,289.4 мянган төгрөгийн материал нь ЗДТГ-ийн, 10.5 хувь буюу 28,513.7 мянган төгрөгийн материал нь хүүхдийн цэцэрлэгийн, 19.2 хувь буюу 52,624.7 мянган төгрөгийн бараа материал нь ЭМТ-ийн бараа материал байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 244,074.8 мянган төгрөгийн, хандив тусламжаар 53,529.3 мянган төгрөгийн, бусад эх үүсвэрээр 26,336.8 мянган төгрөгийн материал худалдан авсан бөгөөд 272,819.4 мянган төгрөгийн материалыг зарцуулж, 3000.0 мянган төгрөгийн материалыг данс хооронд шилжүүлж, малын нас дэвшил болон акталж устгасан зэрэг бусад байдлаар 1,200.0 мянган төгрөгийн материалыг данснаас хасч нийт 277,019.4 мянган төгрөгийн материал хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын данстай холбоотой дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Эрүүл мэндийн төв- Үнэ төлбөргүй хандив тусламжаар ирсэн эмийн үнэд өөрчлөлт орсон тул бараа материалын тайланд 922.7 мянган төгрөгөөр залруулга хийсэн.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл **2,956,268.2 мянган төгрөг**, эцсийн үлдэгдэл **3,493,165.5** төгрөг болж 18.1 хувь буюу 536,897.3 мянган төгрөгөөр өссөн байна. Нийт үндсэн хөрөнгийн 96.0 хувийг биет хөрөнгө, 4.0 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	2,831,294.80	3,369,412.10	538,117.30
Биет бус хөрөнгө	124,973.40	123,753.40	-1,220.00
Дүн	2,956,268.20	3,493,165.50	536,897.30
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Ахлах сургууль	1,613,227.10	1,555,963.00	(57,264.10)
ЗДТГ	759,037.90	1,018,963.60	259,925.70
ИТХ	3,564.50	3,128.20	(436.30)
Соёлын төв	72,144.10	70,019.70	(2,124.40)
Хүүхдийн цэцэрлэг	300,051.90	281,425.70	(18,626.20)
ЭМТ	208,242.70	563,665.30	355,422.60

Дүн	2,956,268.20	3,493,165.50	536,897.30
-----	--------------	--------------	------------

Эх сурвалж: Өгийнуур сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт үндсэн хөрөнгийн 45.0 хувь буюу 1,555,9630.0 мянган төгрөгийн хөрөнгийг ахлах сургууль, 29.0 хувь буюу 1,018,963.6 мянган төгрөгийн хөрөнгийг ЗДТГ, 0.2 хувь буюу 70,019.7 мянган төгрөгийн хөрөнгийг ИТХ, 0.8 хувь буюу 281,425.7 мянган төгрөгийн хөрөнгийг Хүүхдийн цэцэрлэг, 16.0 хувь буюу 563,665.3 мянган төгрөгийн хөрөнгийг ЭМТ эзэмшдэг байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 25,640.2 мянган төгрөг, балансаас баланст шилжүүлэн авсан 6,000.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 733,152.5 мянган төгрөг, бусад эх үүсвэрээс авсан 7361.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн бол балансаас баланст шилжүүлсэн 3000.0 мянган төгрөг, акталсан 182,621.0 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгийн данстай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- ЗДТГ- Санхүүгийн тайлан дахь шинээр нэмэгдсэн 302,589.1 мянган төгрөгийн 14 хөрөнгийн элэгдүүлэх жилийн хугацаа байгууллагад мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй уялдаагүй байна.
- Хүүхдийн цэцэрлэг- Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 44 нэр төрлийн 13,776.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил байгаа бөгөөд тус хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг арга хэмжээг авч ажиллаагүй байна.
- ЭМТ- Үндсэн хөрөнгөд 17,621.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 5,716.3 мянган төгрөгийн тавилга эд хогшил нийт 23,388.2 мянган төгрөгийн хөрөнгө элэгдлээ бүрэн нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгөд арга хэмжээ авч ажиллаагүй байна.
- Ахлах сургууль- БШУС-ын 2017 оны 40 дүгээр тушаалаар баталсан харьяа байгууллагуудад ашиглагдах НБББББ-ийн 2 дугаар хавсралтаар баталсан үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцоход баримтлах хугацааг хөрөнгийн материал, шинж чанараар нь харилцан адилгүй тогтоосон байхад сургуулийн бүх тавилга, эд хогшлыг 10 жилээр, техник тоног төхөөрөмжийг 5 жилээр элэгдэл тооцох хугацааг тогтоосон зэрэг үндсэн хөрөнгийн данс бүртгэлтэй холбоотой зөрчлүүд илэрсэнд аудитаас Сангийн сайдын 388-р тушаалын НББ-ийн дансны зааврын 4.39-т заасны дагуу бүртгэл тайланд тусгах, эд хөрөнгийн үнийг зөвшилцөн тогтоох үед УСНББОУС 23 “Арилжааны бус орлого” гэсэн стандартын 42, 44 дүгээр параграфийн дагуу орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэх, харин ашиглалтын хугацаа дууссан, ашиглагдахгүй болсон хөрөнгийг ТБОНӨТХуулийн 31 дэхь заалтын дагуу арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг менежмент захидлаар хүргүүлэн ажилласан байна.

3.5.8 Өр төлбөр

Тайлант жилд **7,132.0** мянган төгрөгийн өр төлбөр шинээр үүссэн нь Орон нутгийн хөгжлийн сангийн өр төлбөр байна.

Хүснэгт № 5 Өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Байгууллагад төлөх өглөг	0	7,132.0	-7,132.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
ОНХСан	0	7,132.0	-7,132.0
ДҮН	0	7,132.0	-7,132.0

Эх сурвалж: Өгийнуур сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт

Дээрх ОНХС-ийн өр төлбөр нь санхүүжилт оройтож орж ирснээс шалтгаалан төрийн сангийн программ гацаж гүйлгээ хийж чадаагүйтэй холбоотой өр төлбөр байна.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл **3,532,788.6** мянган төгрөг, эцсийн үлдэгдэл **4,099,103.2** мянган төгрөг болж, **566,314.6** мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Цэвэр хөрөнгө өмчийн дансны үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/
Засгийн газрын хувь оролцоо	3,532,788.60	4,099,103.20	566,314.60
Засгийн газрын оруулсан капитал	3,381,535.80	3,381,535.80	0.00
Хуримтлагдсан үр дүн	-511,604.80	120,614.20	632,219.00
Өмнөх үеийн үр дүн	-503,880.00	-445,700.50	58,179.50
Тайлант үеийн үр дүн	-7,724.80	566,314.70	574,039.50
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	662,857.60	596,953.20	-65,904.40
Дүн	3,532,788.60	4,099,103.20	566,314.60
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	3,182,222.10	3,766,040.20	583,818.10
Төсөл, сан	350,566.50	333,063.00	-17,503.50
Дүн	3,532,788.60	4,099,103.20	566,314.60

Эх сурвалж: Өгийнуур сумын ТЭЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хуримтлагдсан үр дүн өмнөх оноос 632,219.0 төгрөгөөр нэмэгдсэн нь дараах дансдуудын өөрчлөлтүүдтэй холбоотой байна. Үүнд:

- Тайлант үеийн үр дүн 574,039.5 мянган төгрөгөөр,
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлттэй холбоотой 58,179.5 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

3.5.10 Орлогын данс

Өгийнуур сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангаар 3,129,771.1 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлогыг тайлагнасан нь өмнөх оноос 517,499.9 мянган төгрөгөөр өссөн байна. Үр дүнгийн тайлангийн нийт орлогыг задалбал:

1. Татварын орлого 113,989.6 мянган төгрөг,
2. Татварын бус орлого 838,426.4 мянган төгрөг байна.
3. Тусламж санхүүжилтийн орлого 2,177,355.1 мянган төгрөг байна. Үүнээс: улсын төсвөөс 1,550,621.5 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 32,619.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 561,172.9 мянган төгрөг, ЭМД-аас 32,940.9 мянган төгрөг байна.

3.5.11 Зардлын данс

Өгийнуур сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны зардал 2,486,674.5 мянган төгрөг, үйл ажиллагааны бус зардал 76,781.9 мянган төгрөг нийт 2,563,456.4 мянган төгрөгийн зардал тайлагнагдаж тайлант үеийн үр дүн өмнөх оноос 566,314.7 мянган болж өссөн нь үнэ төлбөргүй хандив тусламжаар хүлээн авсан хөрөнгөөс шалтгаалсан байна. Тайлант жилд 460,504.2 мянган төгрөгийн санхүүжилт хоорондын тооцоог устгах бичилтээр хийж тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

1. ЗДТГ- Сахилгын шийтгэлтэй 4 албан хаагчдад 360.7 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал тооцож олгосон

2. Соёлын төв- Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал болон БГАҮТХ-ийн зардлаас 2408.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, төсөвт зохицуулалт хийлгэжээр зориулалт бус зарцуулсан байна.
3. БГАҮТХ-ийн зардлаас худалдан авсан дархлаажуулалтын материалыг түлш халаалтын зардалд тайлагнасан байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

✓ **Орон нутгийн төсвийн орлогын талаар:**

Орон нутгийн төсвийн орлогыг 79,675.9 мянган төгрөгөөр анх төсөвлөж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлснийг 18,239.9 мянган төгрөгөөр бууруулан 61,436.0 мянган төгрөгөөр анх баталсан байна. Баталсан орлогоос шууд бус орлогыг төлөвлөснөөс 19,849.0 мянган төгрөгөөр бууруулсан нь шууд бус орлогоос орох орлогыг бүрэн төлөвлөх боломжгүй байсантай холбоотой байна.

Харин төсөв батлах тухай тодотгосон тогтоолоор орон нутгийн орлогыг 26,734.0 мянган төгрөгөөр 1 нэр төрлийн орлогыг нэмэгдүүлэн 15 нэр төрлийн 88,170.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна. Харин гүйцэтгэлээр 121,878.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 38.2 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 7. Сумын орон нутгийн төсвийн орлого

/мянган төгрөг/

№	Орлогын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ОРЛОГО	88,170.00	121,878.00	33,708.00	138.2
2	УРСГАЛ ОРЛОГО	88,170.00	121,878.00	33,708.00	138.2
3	ТАТВАРЫН ОРЛОГО	83,120.00	113,989.30	30,869.30	137.1
4	Орлогын албан татвар	66,820.00	92,835.40	26,015.40	138.9
5	Хүн амын орлогын албан татвар	66,820.00	92,835.40	26,015.40	138.9
6	Үйл ажиллагааны орлого	2,160.00	2,695.00	535.00	124.8
7	Шууд бус орлого	29,560.00	45,068.90	15,508.90	152.5
8	Хөрөнгийн орлого /хадгаламжийн хүүнээс/	35,000.00	44,613.50	9,613.50	127.5
9	Үл хөдлөх хөрөнгө борлуулсаны орлого	100.00	458.00	358.00	458.0
10	Өмчийн татвар	2,700.00	3,120.00	420.00	115.6
11	Бууны албан татвар	2,700.00	3,120.00	420.00	115.6
12	Бусад татвар	13,600.00	18,033.90	4,433.90	132.6
13	Улсын тэмдэгтийн хураамж	1,920.00	1,008.90	(911.10)	52.5
14	Газрын төлбөр	416.00	1,440.30	1,024.30	346.2
15	Газрын төлбөр	-	578.30	578.30	100.0
16	Газрын дуудлага худалдааны орлого	416.00	862.00	446.00	207.2
17	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	264.00	266.00	2.00	100.8
18	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	8,000.00	12,136.70	4,136.70	151.7
19	Байгалын нөөц ашигласны төлбөр	3,000.00	3,182.00	182.00	106.1
20	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	3,000.00	3,182.00	182.00	106.1
21	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,050.00	7,888.70	2,838.70	156.2
22	Төсөвт газрын өөрийн орлого	650.00	2,232.10	1,582.10	343.4
23	Хүү торгуулийн орлого	3,400.00	2,704.10	(695.90)	79.5
24	Нэр заагдаагүй бусад орлого	1,000.00	2,952.50	1,952.50	295.3

Тайлант жилд 13 нэр төрлийн орлого давж биелэсэн бол улсын тэмдэгтийн хураамжийн орлого 911.1 мянган төгрөгөөр, хүү торгуулийн орлого 695.9 мянган төгрөгөөр тус тус тасарсан нь Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14 заалтыг үндэслэн сургууль хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор тамхи худалдахыг хориглоно

гэж заасны дагуу тамхины зөвшөөрөл хүссэн дэлгүүрийн худалдаа эрхлэгч нарт зөвшөөрөл олгогдоогүй, коронавирус /Ковид-19/ цар тахал гарсантай холбогдуулан хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбоотой байна.

Төсвийн төлөвлөлт

Өгийнуур сумын ИТХ-ын 2020 оны төсөв батлах тогтоолоор сумын нийт орлого, санхүүгийн дэмжлэг, төсөвт байгууллагуудад олгох санхүүжилтийг 2,569,371.6 мянган төгрөгөөр анх баталсан бол тодотгосон тогтоолоор 2,423,614.5 мянган төгрөг болж 143,757.1 мянган төгрөгөөр бууруулсан байна.

Хүснэгт 8. Сумын төсвийн төлөвлөлт /мянган төгрөг/

№	Байгууллага, орлогын нэр төрөл	Анх баталсан дүн	Тодотгон баталсан дүн	Зөрүү
1	Сумын төсвийн татварын орлого	60,786.0	88,170.0	27,384.0
2	ТЭЗ-ийн харьяа байгууллагын төвлөрүүлэх орлого	123,800.0	123,800.0	-
3	Аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	344,596.5	313,946.5	(30,650.0)
4	ОНХС-ийн орлогын шилжүүлэг	61,351.4	59,470.2	(1,881.2)
5	СӨБ-ийн үйлчилгээ	345,828.7	296,761.6	(49,067.1)
6	ЕБС-ийн үйлчилгээ	1,023,814.1	920,695.9	(103,118.2)
7	Соёлын үйлчилгээ	81,765.8	81,765.8	-
8	ЭМ-ийн анхан шатны тусламж үйлчилгээ	478,779.1	477,624.8	(1,154.3)
9	2019 оны ОН-ийн төсвийн үлдэгдлээс санхүүжих дүн	38,500.0	51,876.8	13,376.8
10	2020 оны ОНХС-ийн төсвийн үлдэгдлээс санхүүжих дүн	9,500.0	9,502.9	2.9
	Нийт дүн	2,569,371.6	2,423,614.5	(145,757.1)
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	58,645.3	58,645.3	-
2	Засаг даргын тамгын газар	372,065.7	379,526.5	7,460.8
3	Орон нутгийн нөөц хөрөнгө	13,821.5	15,821.5	2,000.0
4	Орон нутгийн хөгжлийн сан	70,851.4	68,973.1	(1,878.3)
5	Сум хөгжүүлэх сан	121,800.0	121,800.0	-
6	Сургуулийн өмнөх боловсрол	345,828.7	296,761.6	(49,067.1)
7	Ерөнхий боловсролын сургууль	1,023,814.1	920,695.9	(103,118.2)
8	Соёлын төв	83,765.8	83,765.8	-
9	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	478,779.1	477,624.8	(1,154.3)
	Нийт дүн	2,569,371.6	2,423,614.5	(145,757.1)

Тайлант онд төсвийн орлогын эхний хагас жилийн гүйцэтгэлийг үндэслэн зарим нэр төрлийн орлогыг нэмэгдүүлэн баталсан бол

1. ЭМТ-ийн тогтмол зардал 1,154.3 мянган төгрөгөөр,
2. Аймагт ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл цуцлагдаж орох орлого буурсан зэрэгтэй уялдуулан орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 1878.3 мянган төгрөгөөр
3. ЗДТГ-Цар тахалтайгаар холбоотойгоор зочин төлөөлөгч хүлээн авалт, албан томилолт тавилга, эд хогшил, урсгал засвар зэрэг тэвчиж болох зардлуудыг бууруулж, зарим өртэй гарах зардал руу 7460.8 мянган төгрөгөөр
4. Ковид-19 цар тахалтай холбогдуулан тусгай зориулалтын шилжүүлэгийн байгууллагын /сургууль, цэцэрлэг/ үйл ажиллагаа түр хаасантай

холбоотойгоор тусгай зориулалтын шилжүүлгээс 152,185.3 мянган төгрөгөөр тус тус хасаж тодотгол хийгдсэн байна.

✓ **Орон нутгийн төсвийн зардлын талаар:**

Өгийнуур сум нийт зардлын төлөвлөгөөг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 06 тоот тогтоолоор 2,569,371.6 мянган төгрөгөөр анх баталсан бөгөөд Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 05 тоот тогтоолоор төсвийн зохицуулалт хийж, ЗДТГ-т 7,460.8 мянган төгрөгийн, СӨБ-т 49,067.1 мянган төгрөгийн, ЕБС-т 103,118.2 мянган төгрөгийн, ЭМТ 1,154.3 мянган төгрөгийн хасах тодотгол хийж, нийт зардлын хэмжээг 2,423,614.5 мянган төгрөгөөр баталжээ.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 2,423,614.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,223,641.4 мянган төгрөгийг урсгал зардалд, 79,973.1 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 120,000.0 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,555,885.8 мянган төгрөг буюу 64.1 хувийг улсын төсвөөс, 648,693.0 мянган төгрөг буюу 26.7 хувийг орон нутгийн төсвөөс, 33,206.0 мянган төгрөг буюу 1.7 хувийг ЭМД-аас, 185,829.7 мянган төгрөг буюу 7.6 хувийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,302,011.1 мянган төгрөг буюу 94.6 хувьтай байгаа нь урсгал зардлаас 56,507.9 мянган төгрөг, хөрөнгийн зардлаас 7,923.2 мянган төгрөг, сум хөгжүүлэх сангаас 65,000.0 мянган төгрөг хэмнэгдэж зарцуулаагүйтэй холбоотой байна.

Тайлант жил ОНХС болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 4 төсөл, арга хэмжээнд 68,973.1 мянган төгрөгийн санхүүжилт зарцуулагдсан байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс 1,168.7 мянган төгрөг, Дээд шатны төсөв захирагчаас 25,402.7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 6,048.4 мянга төгрөг нийт 32,619.8 мянган төгрөгийг бүрдүүлсэн байна. Үүнээс Хүүхдийн цэцэрлэгт 105.0 мянган төгрөг, Эрүүл мэндийн төв 7,942.7 мянган төгрөг, ЗДТГ-т 18,628.7 мянган төгрөг, Ахлах сургууль 5,943.4 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 180 мэдээллээс 170 мэдээллийг хугацаанд нь, 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар 9,272.5 мянган төгрөгийг аудитын явцад залруулж, 67,989.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна.

Хүснэгт №9 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	2	67,989.0	2	67,989.0			50
Нийт	2	67,989.0	2	67,989.0			50

СХС-ийн авлагыг барагдуулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллаж байгаа гэсэн албан бичгээр зөвлөмжийн хариуг ирүүлсэн боловч энэ жил хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оноос 5,437.5 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байгаа тул биелэлтийг 50 хувьтай байна гэж үзэн тайлант оны аудитаар ахин зөвлөмж хүрүүлэх шаардлагатай гэж үзсэн.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Өгийнуур сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Өгийнуур сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагад аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт №10.Аудитын дүнгийн талаар:

Байгууллагын нэр	Байгууллагын тоо								Аудитын санал дүгнэлтийн төрөл					
	Хамрагдвал зохих	Төлөвлөсөн			Хамрагдсан	Гүйцэтгэсэн			Бүгд	Үүнээс				
		Бие дааж дүгнэлт гаргах	Түүвэрт хамруулах	Итгэл үзүүлэх		Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Итгэл үзүүлсэн		Аудит хийгдээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс
Ахлах сургууль	1	1		1	1			1	1					
Хүүхдийн цэцэрлэг	1	1		1	1			1	1					
ЗДТГ	1	1		1	1			1	1					
ИТХурал	1	1		1	1			1	1					
Эрүүл мэндийн төв	1	1		1	1			1	1					
Соёлын төв	1		1	1		1								
ОНХС	1		1	1		1								
СХС	1		1	1		1								
НИЙТ ДҮН	8	5	3	-	8	5	3	-	-	5	5	-	-	-

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн 5 төсөвт байгууллагад “Зөрчилгүй” санал дүгнэлт өгч, соёлын төв, 2 төсөл санг түүвэрт хамруулсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 345,022.7 мянган төгрөгийн төлбөр зөрчил илэрч 1,303.7

мянган төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, 340,949.7 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж, 2,408.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 361.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт хүргүүлэн ажилласан байна.

Хүснэгт №11. Төсвийн шууд захирагчдын төлбөр зөрчлийн нэгтгэл /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Залруулсан алдаа		Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
					Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ахлах сургууль			2	-			1		1	
Хүүхдийн цэцэрлэг			1	13,776.30					1	13,776.30
ЗДТГ			2	302,949.80	1	360.70			1	302,589.10
ИТХурал			2	1,196.10					2	1,196.10
Эрүүл мэндийн төв	1	922.70	1	23,388.20					1	23,388.20
Соёлын төв	1	380.00	1	2,408.60			1	2,408.60		
НИЙТ ДҮН	2	1,303.7	9	343,719.00	1	361.70	2	2,408.60	6	340,949.70

Алдаа зөрчлийг ангиллаар нь харуулбал Балансын данстай холбоотой 340,676.3 мянган төгрөгийн, арвилан хэмнэлттэй холбоотой 360.7 мянган төгрөгийн, зардлын данстай холбоотой 2788.6 мянган төгрөгийн, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 1,196.1 мянган төгрөгийн алдаа зөрчил тус тус илэрсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар:

Өгийнуур сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 82,165.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 7,132.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 75,033.5 мянган төгрөгийн зөрчилд менежмент захидлаар зөвлөмж хүргүүллээ.

Хүснэгт №12 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төлбөр зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
			Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сум хөгжүүлэх сан	1	73,426.5					1	73,426.5
Орон нутгийн хөгжлийн сан	1	7,132.0			1	7,132.0		
Нэгдсэн тайлан	2	1,607.0					2	1,607.0
НИЙТ ДҮН	4	82,165.5			1	7,132.0	3	75,033.5




1. Шилэн дансны мэдээллийг тулган шалгахад 170 мэдээллийг хугацаанд нь 10 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсанд аудитаас зөвлөмж хүргүүллэ.
2. Өгийнуур сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөвт зохицуулалт хийх тухай 05-р тогтоолд сумын төсвийн орлогоор 15 нэр төрлийн 88,170.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 121,878.0 мянган төгрөгийн орлогыг

төвлөрүүлж, төлөвлөгөөг 38.2 хувиар давуулан биелүүлсэн байна. Тайлант жилд 13 нэр төрлийн орлого давж биелэсэн бол улсын тэмдэгтийн хураамжийн орлого 911.1 мянган төгрөгөөр, хүү торгуулийн орлого 695.9 мянган төгрөгөөр тус тус тасарсанд аудитаас зөвлөмж хүргүүллээ.

3. Авлагын бүртгэлийг тулган үзэхэд хэвийн зээлийн хэмжээ 209,344.3 мянган төгрөг, хугацаа хэтэрсэн зээл 48,149.2 мянган төгрөг, чанаргүй зээл 25,277.3 мянган төгрөг байгаа зөрчилд холбогдох арга хэмжээнүүдийг авч ажиллах зөвлөмж хүргүүллээ.
4. ОНХС-ийн 7,132.0 мянган төгрөгийн өр төлбөртэй байна. Дээрх өр төлбөр нь санхүүжилт оройтож орж ирснээс шалтгаалан төрийн сангийн программ гацаж гүйлгээ хийж чадаагүйтэй холбоотой бий болсон өр төлбөрт аудитаас албан шаардлага хүргүүллээ.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитад төсөв батлах тухай тогтоолыг үнэн зөв хийсэн эсэхийг нягтлах

АУДИТЫН ТАЙЛАН			
Бэлтгэсэн:	Аудитор		Х.Алтанчимэг
Анхан шатанд хянасан:	Аудитын менежер		Т.Байгалмаа
Хоёр дахь шатанд хянасан:	Тэргүүлэх аудитор		Д.Уламбаяр

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 ОРЛОГЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

4.1.1 Илрүүлэлт: Өгийнуур сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөвт зохицуулалт хийх тухай тухай 05-р тогтоолд сумын төсвийн орлогоор 15 нэр төрлийн 88,170.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 121,878.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 38.2 хувиар давуулан биелүүлсэн байна. Тайлант жилд 13 нэр төрлийн орлого давж биелэсэн бол улсын тэмдэгтийн хураамжийн орлого 911.1 мянган төгрөгөөр, хүү торгуулийн орлого 695.9 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

4.1.2 Эрсдэл: Орон нутгийн орлого дутуу төвлөрөх

4.1.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 41.2.1 дэх заалтыг хэрэгжүүлэн төсөвт төвлөрөх орлогыг бүрэн төвлөрүүлэхэд анхаарч, орлогыг жигд ханган биелүүлж ажиллах.

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

4.2 ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ:

4.2.1 Илрүүлэлт: Өгийнуур сумын шилэн дансны мэдээллийг тулган шалгахад 170 мэдээллийг хугацаанд нь 10 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна

4.2.2 Эрсдэл: Мэдээллийн ил тод байдал алдагдах, иргэд олон нийт мэдээллээр хангагдахгүй байх

4.2.3 Өгсөн зөвлөмж: *Шилэн дансны тухай хуулийн 6.4.8 бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг тухай бүр байршуулах заалтыг хэрэгжүүлэн мэдээллийг тогтмол шилэн дансанд мэдээлж ажиллах*

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

4.3 Авлагын данстай холбоотой асуудал:

- 4.3.1 **Илрүүлэлт:** Авлагын бүртгэлийг тулган үзэхэд хэвийн зээлийн хэмжээ 209,344.3 мянган төгрөг, хугацаа хэтэрсэн зээл 48,149.2 мянган төгрөг, чанаргүй зээл 25,277.3 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 5,437.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.
- 4.3.2 **Эрсдэл:** Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт, эх үүсвэр боломжит хэмжээнд төвлөрөхгүй байх, зарцуулалт үр дүнгүй болох улмаар найдваргүй авлага үүсэх эрсдэлийг бий болгож болзошгүй байна.
- 4.3.3 **Өгсөн зөвлөмж:** *Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг батлагдсан төлөвлөгөөний дагуу бүрэн биелүүлэхэд цаг алдалгүй тодорхой арга хэмжээ авч, Засгийн газрын 2016 оны 153-р тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмыг мөрдөж ажиллах*
- 4.3.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2021 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.03.25	Аудитын нэр:	Өгийнуур сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код: АРА-2021/11/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Өгийнуур сумын ТЭЗ		мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Өгийнуур сумын шилэн дансны мэдээллийг тулган шалгахад 170 мэдээллийг хугацаанд нь 10 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.		Зөвлөмж өгөх	Засаг дарга, Санхүү албаны дарга	Ш.Үүрцайх, Д.Ундармаа
2	Өгийнуур сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөвт зохицуулалт хийх тухай тухай 05-р тогтоолоор 15 нэр төрлийн 88,170.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 121,878.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 38.2 хувиар давуулан биелүүлсэн байна. Тайлант жилд 13 нэр төрлийн орлого давж биелэсэн бол улсын тэмдэгтийн хураамжийн орлого 911.1 мянган төгрөгөөр, хүү торгуулийн орлого 695.9 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.	1,607.0	Зөвлөмж өгөх	Засаг дарга, Санхүү албаны дарга	Ш.Үүрцайх, Д.Ундармаа
3	Авлагын бүртгэлийг тулган үзэхэд хэвийн зээлийн хэмжээ 209,344.3 мянган төгрөг, хугацаа хэтэрсэн зээл 48,149.2 мянган төгрөг, чанаргүй зээл 25,277.3 мянган төгрөг байна.	73,426.5	Зөвлөмж өгөх	Засаг дарга, Санхүү албаны дарга	Ш.Үүрцайх, Д.Ундармаа
4	Өгийнуур сумын ОНХС-ийн санхүүгийн тайланд 7,132.0 мянган төгрөгийн өр төлбөртэй байна. Дээрх өр төлбөр нь санхүүжилт оройтож орж ирснээс шалтгаалан төрийн сангийн программ гацаж гүйлгээ хийж чадаагүйтэй холбоотой бий болсон өр төлбөр байна.	7,132.0	Албан шаардлага хүргүүлэх	Засаг дарга, Санхүү албаны дарга	Ш.Үүрцайх, Д.Ундармаа
	ДҮН	82,165.5			



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 118/А0370214
АРА - 202102 - СТА - ТТЗ

Цэцэрлэг

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Өгийнуур сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийхэд ОНХС-ийн жилийн эцсийн санхүүгийн тайланд 7,132.0 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн "6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн Аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын ерөнхий аудиторын 2019 оны а/95 дугаар тушаалаар баталсан төлбөрийн акт, албан шаардлага өгөх журам"-ын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх, үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Дээрх өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах

Албан шаардлагын биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 01-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг дарга Өгийнуур сумын засаг дарга Ш.Үүрцайх, санхүү албаны дарга Д.Ундармаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Аудитын менежер

Т.Байгалмаа

Аудитор:

Х.Алтанчимэг

